

Сангийн сайдын 2019 оны 295 дугаар тушаалаар  
батлагдсан журмын 2 дугаар хавсралт  
Маягт 3-02

**МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА  
ТАТВАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ**

2019 оны 09 сарын 01 өдөр

Дугаар: 01

Улаанбаатар хот

**НЭГ. ЗӨВЛӨМЖТЭЙ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НЭР, БАТЛАГДСАН  
ОГНОО, ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТ, ДЭД ЗААЛТЫН ДУГААР:**

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9, 22.10, 22.11, 22.12, 22.13 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1.12 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.6, 15.1.7, 15.1.8, 15.1.9, 15.1.10, 15.1.16, 15.1.17 дахь заалт;
- Татварын ерөнхий хуулийн 10 дугаар зүйл, 78 дугаар зүйлийн 78.1.1 дэх заалт;
- Засгийн газрын гишүүний баталсан бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандартууд;

**ХОЁР. СУДАЛГАА, ДҮГНЭЛТ:**

2.1 Үүссэн нөхцөл байдал

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд 2024 оны 08 дугаар сарын 30-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулж тус хуулийн Албан татварын хөнгөлөлтийн 22 дугаар зүйлд 22.9-22.13 дахь хэсгийг нэмсэн бөгөөд 2035 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл дагаж мөрдөхөөр заасан. Мөн хуулийн 16 дугаар зүйл 16.1.12 дахь заалтад өөрчлөлт оруулж, 15 дугаар зүйлийн 15.1.6, 15.1.7, 15.1.8, 15.1.9, 15.1.10, 15.1.16, 15.1.17 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсон.

Энэхүү зохицуулалтын хүрээнд албан татвар төлөгчийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татвараас орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй мөн хуулийн 22.9-д заасан үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг тухайн татварын жилийн татвар ногдох орлогын 1 хувь хүртэл хэмжээнээс хэтрэхгүй байх бөгөөд, төлбөл зохих албан татвараас хасаж тооцно.

Түүнчлэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.11-д тус хөнгөлөлтийг эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандартыг салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, хяналт тавих тухай тус тус заасан.

Татвар төлөгчдөд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт болох 22 дугаар зүйлийн 22.9-д заасан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандивын зардлын дүнгээр хөнгөлөлт эдлэхтэй холбоотой дараах асуудлуудыг тодорхой болгох шаардлага үүссэн. Үүнд:

1. Хуулийн 22 дугаар зүйл 22.9-д заасан албан татварын хөнгөлөлтийг тооцоолох;
2. Хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг хөнгөлөлт эдэлсэн татвар төлөгч хасагдах зардалдаа оруулан тооцох эсэх;
3. Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт гэдэгт хамаарах хөрөнгийг хэрхэн тодорхойлох;
4. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасан бусад албан татварын хөнгөлөлттэй давхардуулан эдлүүлэх эсэх;
5. Хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандивын орлогыг хүлээн авагч этгээд нь орлогоор хүлээн зөвшөөрч, уг орлогод албан татвар ногдуулах эсэх, харилцан хамаарал бүхий этгээдийг тодорхойлох;
6. Албан татварын хөнгөлөлтийн бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах хуулийн болон салбар яамны шаардлага;
7. Албан татварын хөнгөлөлтийг тайланд тусгах;
8. Албан татварын хөнгөлөлтийн тайлан хянах, хүлээн авах;
9. Бусад.

Иймд Татварын ерөнхий хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.1-д татвар төлөгчийн хүсэлтэд үндэслэн, эсхүл татварын албаны санаачилгаар татварын хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх зөвлөмж гаргаж болно гэж заасны дагуу улсын хэмжээнд хуулийн 22 дугаар зүйл 22.9 дэх хэсгийн хэрэгжилтийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх зөвлөмжийг гаргаж байна.

## 2.2 Хууль, эрх зүйн орчин

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйл 22.9. Албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй доор дурдсан үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татвараас хасаж хөнгөлнө. Хөнгөлөх дүн нь тухайн татварын жилийн татвар ногдох орлогын 1 хувь хүртэл хэмжээнээс хэтрэхгүй байна:
  - 1.1. 22.9.1.ой, амьтан, ус зэрэг байгалийн баялаг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, зохистой ашиглах, нөхөн сэргээх, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, цөлжилтийг сааруулах;
  - 1.2. 22.9.2.ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамжийн үйлчилгээ, тэдгээрийн эрхийг хангах, хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргээдэд зориулсан тохицуулгат орчин бүрдүүлэх, хүүхдийн тоглоомын талбай, зуслан, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах, ашиглах;

- 1.3. 22.9.3.соёлын өвийг хамгаалах, сэргээх, музей, номын сангийн үйл ажиллагаа болон хөгжим, кино, гар урлал, тайзны урлагийн бүтээл туурвих, тоглох, түгээх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор барьж байгуулах, ашиглах;
  - 1.4. 22.9.4.нийтийн эзэмшлийн зам, талбай, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах, ашиглах, хамгаалах, тохижуулах, цэцэрлэгжүүлэх, нийтийн тээврийн хөгжлийг дэмжих;
  - 1.5. 22.9.5.давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамшигийн улмаас хохирол барагдуулах;
  - 1.6. 22.9.6.спортын барилга байгууламж барьж байгуулах, ашиглах, олимпын төрлийн тэмцээн зохион байгуулах, Монголын үндэсний олимпын хорооны бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг;
  - 1.7. 22.9.7.Монгол Улсын Засгийн газраас зарласан тэргүүлэх чиглэлээр гадаадын их, дээд сургууль, дотоодын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуульд суралцаж байгаа оюутан, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид олгосон сургалтын төлбөрийн тэтгэлэг;
  - 1.8. 22.9.8.их, дээд сургууль, шинжлэх ухааны академид судалгаа, шинжилгээний зориулалтаар олгосон тэтгэлэг;
  - 1.9. 22.9.9.төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа;
  - 1.10. 22.9.10.Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагаа;
  - 1.11. 22.9.11.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдийн хуульд заасан үйл ажиллагаа;
  - 1.12. 22.10.Энэ хуулийн 22.9.1-д заасан нөхөн сэргээх зардалд энэ хуулийн 13.4, 22.5.9-д зааснаас бусад нөхөн сэргээх зардал хамаарна.
  - 1.13. 22.11.Энэ хуулийн 22.9-д заасны дагуу хөнгөлөлт өдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандартыг салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, хяналт тавина.
  - 1.14. 22.12.Энэ хуулийн 22.9-д заасан хөнгөлөлтөд хамаарах зардал нь энэ хуулийн 13.1.1, 13.1.3, 13.1.4, 13.1.5-д заасан шаардлагыг хангасан байна.
  - 1.15. 22.13.Энэ хуулийн 22.9-д заасан хөнгөлөлтөд хамаарах хөрөнгө оруулалт, зардлыг татварын албанаас баталсан маягтын дагуу энэ хуулийн 26.1, 26.2-т заасан тайланд хавсаргаж тайлагнана
2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9-д заасны дагуу албан татвараас хөнгөлөгдөх бөгөөд энэ заалтыг 2035 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл дагаж мөрдөнө.
  3. Зам тээврийн сайдын 2024.12.16-ны өдрийн A/272 тоот тушаал “Шаардлага батлах тухай”
  4. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024.12.12-ны өдрийн A/67 тоот тушаал “Шаардлага батлах тухай”
  5. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024.12.12-ны өдрийн A/93 тоот тушаал “Үйл ажиллагаанд тавигдах шаардлага батлах тухай”

6. Монгол Улсын шадар сайдын 2025.02.05-ны өдрийн 18 тоот тушаал “Шаардлага батлах тухай”
7. Эрүүл мэндийн сайдын 2025.05.07-ны өдрийн А/189 тоот тушаал “Нийтлэг шаардлага шинэчлэн батлах тухай”
8. Боловсролын сайдын 2025.05.02-ны өдрийн А/189 тоот тушаал “Шаардлага батлах тухай”
9. Соёл, спорт, аялал жуулчлал, запуучуудын сайдын 2025.05.07-ны өдрийн А/175 тоот тушаал “Шаардлага батлах тухай”
10. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025.05.12-ны өдрийн 105 тоот тушаал “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага батлах тухай”
11. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025.05.09-ний өдрийн А/79 тоот тушаал “Хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага стандарт, батлах тухай”
12. Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025.06.13-ны өдрийн А/76 тоот тушаал
13. Бусад нэмж батлагдах яамны шаардлага, стандарт

#### **ГУРАВ. ЗӨВЛӨМЖ БОЛГОХ НЬ:**

- 3.1. Хуулийн 22 дугаар зүйл 22.9-д заасан албан татварын хөнгөлөлтийг тооцоолох:

- Хөнгөлөгдөх дүн нь тухайн татварын жилийн татвар ногдох орлогын 1 хувь хүртэл байх бөгөөд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйл 20.1-д заасны дагуу нийтлэг хувь хэмжээгээр ногдуулан тайлант жилийн төлбөл зохих албан татварын дунгээс хасаж тооцно.

Салбар яамд өөрийн эрхлэх асуудлын салбарын бодлоготой нийцүүлэн хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандартыг баталсан. Татвар төлөгчид тухайн салбарт хийх хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэгийг тухайн шаардлага, стандартад нийцүүлэн хэрэгжүүлж, тайландаа холбогдох баримт бичгийг хавсарган илгээнээр хөнгөлөлт эдэлнэ.

Энэхүү албан татварын хөнгөлөлтийг дараагийн татварын жилд шилжүүлэн тооцохгүй.

- 3.2. Хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг хөнгөлөлт эдэлсэн татвар төлөгч хасагдах зардалдаа оруулан тооцох эсэх:

- Нийгмийн хариуцлагын хүрээнд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандивын зардал нь тухайн татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай шууд холбогдон гараагүй зардал бөгөөд хуулийн 22.9-д заасан албан татварын хөнгөлөлт эдэлж, борлуулалтын орлогын 1%-иас хэтрэхгүй дунгээр төлбөл зохих албан татвараас хасаж тооцно.

Мөн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.12-т энэ хуулийн 13.1.1, 13.1.3, 13.1.4, 13.1.5-д заасан шаардлагыг хангасан байх гэж заасан бөгөөд үндсэн үйл ажиллагааны орлого олохтой холбогдон гараагүй, хуулийн 13

дугаар зүйлийн 13.1-д заасан нөхцөлийг нэгэн зэрэг хангасан зардлыг албан татвар ногдох орлогоос хасаж тооцно гэснийг бүрэн хангаагүй байх тул хасагдахгүй зардалд бүртгэнэ

3.3. Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт гэдэгт хамаарах хөрөнгийг хэрхэн тодорхойлох:

- Татвар төлөгчийн элэгдэл тооцох үндсэн хөрөнгө гэдэг нь эдийн засгийн ирээдүйд өгөөж хүртэх магадлалтай, хөрөнгийн өртөг эсхүл бодит үнэ цэнийг үнэлэх боломжтой, нэгээс дээш жил ашиглах барилга байгууламж, газрын тохижилт, нэгээс дээш тайлант хугацаанд ашиглагдах биет хөрөнгө байна.

Бусад хуулийн этгээдэд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийж буй тохиолдолд авч буй этгээдтэй гэрээ байгуулан нотариатаар гэрчлүүлж, хөрөнгө оруулалт авч буй талын санхүүгийн тайланд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэн, төлбөрийн баримтаар баталгаажуулсан байх ба албан татварын хөнгөлөлт нь туслан гүйцэтгэгч болон дамжуулагч этгээдэд хамаарахгүй. Нийгмийн хариуцлагын хүрээнд өөрийн үндсэн хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх тохиолдолд бизнес төлөвлөгөөнд тусгаж, салбарын яамны баталсан шаардлага, стандартад нийцсэн, тухайн хөрөнгө оруулалтын өртөг төлбөрийн баримтаар баталгаажсан, санхүүгийн тайланд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэсэн байна.

Хөрөнгө оруулах үйл ажиллагааг олон улсын байгууллагаар дамжуулах, хамтран хэрэгжүүлэх тохиолдолд дамжуулагч болон хамтран хэрэгжүүлэгч этгээдтэй холбоотой гарсан зардлыг хөрөнгө оруулалтын дүнгээс хасаж тооцох бөгөөд албан татварын хөнгөлөлт эдлэх дүнд оруулан тооцохгүй.

3.4. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасан бусад албан татварын хөнгөлөлттэй давхардуулан эдлүүлэх эсэх:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 эсхүл 22.5-д заасан албан татварын хөнгөлөлтийн заалттай хамтад нь хэрэглэж болно. Энэ тохиолдолд 20 дугаар зүйл 20.1-д заасны дагуу нийтлэг хувь хэмжээгээр ногдуулан тайлант жилийн төлбөл зохих албан татварын дүнгээс хуулийн 22.9-д заасан албан татварын хөнгөлөлтийг хасаж тооцсоны дараах дүнгээс 22.1 эсхүл 22.5-д заасан албан татварын хөнгөлөлтийг тооцно.

Хуулийн 22.1 болон 22.5-д заасан хөнгөлөлтийг хуульд заасан хугацаанд төлсөн албан татварын дүнгээс хэтрүүлэн эдлүүлэхгүй.

Харин хуулийн 29.1, 20.2.7-д заасны дагуу албан татвар төлж, тайлагнах аж ахуйн нэгж 22.9-д заасан хөнгөлөлтийг эдлэхгүй.

3.5. Хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандивын орлогыг хүлээн авагч этгээд нь орлогоор хүлээн зөвшөөрч, уг орлогод албан татвар ногдуулах эсэх:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-т үнэ төлбөргүйгээр бусдаас авсан бараа, ажил, үйлчилгээний орлогыг албан

татвар ногдох орлого гэж заасан. Иймд хөрөнгө оруулалт болон санхүүгийн дэмжлэг, хандив хүлээн авсан этгээд нь төлбөрийн баримт олгох бөгөөд өөрийн татварын тайланд албан татвар ногдох орлогоор тусган албан татвар төлж, тайлагнана.

Мөн элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд хөрөнгө оруулалт авсан этгээд нь төлбөрийн баримтыг олгож үндсэн хөрөнгийг шилжүүлэн авснаар тайланд тусгах бөгөөд санхүүгийн тайланд бүртгэж авснаас хойш татварын зорилгоор элэгдэл тооцохгүй.

Харилцан хамааралтай этгээд гэдгийг Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасныг ойлгоно.

3.6. Албан татварын хөнгөлөлтийн бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага:

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйл 22.9- 22.13 дахь заалт, мөн 22.12-т заасны дагуу салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандарт болон бусад баримтлах дүрэм, журам жагсаалтын дагуу дараах шаардлагыг хангасан байна.

a.Хөнгөлөлт эдлэхэд тавигдах хуулийн шаардлага

- Засгийн газрын гишүүний баталсан шаардлага, стандартад нийцсэн байх;
- Тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын хүрээнд хөрөнгө оруулсан, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн, хандив олгосон байх;
- Хөнгөлөлт эдлэх дүн нь тухайн татварын жилийн татвар ногдох орлогын 1 хувь хүртэл хэмжээнээс хэтрэхгүй байх;
- Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандив нь аж ахуйн нэгжийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй байх;
- Хөрөнгө оруулалт хийсэн, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн, хандив өгсөн нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д заасан төлбөрийн баримтаар баталгаажсан байх;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.1, 13.1.3, 13.1.4, 13.1.5-д заасан шаардлагыг хангасан байх бөгөөд хасагдахгүй зардалд тусгасан байх
- Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт нь харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн бол бодит үнэ тодорхойлох зарчмыг баримтлах /ажил гүйлгээний нөхцөл нь татварын зорилгоор түүнтэй харьцуулж болох бие даасан ажил гүйлгээний нөхцөлөөс ялгаатай байгаагаас татварын суурь багассан бол тухайн ажил гүйлгээний бодит үнийг тодорхойлж, татварын ногдолд тохируулга хийнэ/

б.Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалтад тавигдах нийтлэг шаардлага:

- Татвар төлөгчийн нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт бусад этгээдэд хөрөнгө оруулалт хийх тохиолдолд хөрөнгө оруулалт авч буй талын санхүүгийн тайланд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэгдсэн байх /туслан гүйцэтгэгч, дамжуулагч этгээдэд хамаarahгүй/
- Нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт татвар төлөгчийн өөрийн хэрэгжүүлэх бүтээн байгуулалт, төсөл үйл ажиллагааны хувьд тухайн татвар төлөгчийн удирдах дээд байгууллагын баталсан бизнесийн төлөвлөгөөнд туссан, хөрөнгө оруулалт авч буй этгээдийн санхүүгийн тайланд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэгдсэн байх /туслан гүйцэтгэгч, дамжуулагч этгээдэд хамаarahгүй/
- Хөрөнгө оруулалт хийх гэрээ байгуулж, гэрээг нотариатаар гэрчлүүлсэн байх;
- Монгол Улсын нутаг дэвсгэрт элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан бодитой хөрөнгө оруулалт байх;
- Салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан стандарт шаардлагын бусад нөхцөлийг хангасан байх

в. Санхүүгийн дэмжлэг, хандивт тавигдах нийтлэг шаардлага:

- Хариу төлбөргүй шилжүүлсэн мөнгөн болон биет хөрөнгө байх;
- Санхүүгийн дэмжлэг, хандив хүлээн авагч нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хандив олгох татвар төлөгчтэй Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасан харилцан хамааралгүй байх;
- Санхүүгийн дэмжлэг, хандив нь Иргэний хуулийн 276 дугаар зүйл 276.6, 279 дүгээр зүйлд заасан тусгай зориулалтын бэлэглэлийн гэрээний шаардлагыг хангасан байх ба нотариатаар баталгаажуулсан байх;
- Санхүүгийн дэмжлэг, хандив олгосон болон хүлээн авсан этгээд нь тухайн санхүүгийн дэмжлэг, хандивыг гэрээнд тусгасан зориулалтын дагуу тухайн тайлант хугацаанд зарцуулсан гэдгийг хүлээн зөвшөөрч, гэрээг цуцлах болон татгалзахгүй тухайгаа илэрхийлсэн акт үйлдсэн байх;
- Санхүүгийн дэмжлэг, хандивын зардал нь Татварын ерөнхий хуулийн хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх;
- Салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан стандарт шаардлагын бусад нөхцөлийг хангасан байх.

3.7. Албан татварын хөнгөлөлтийг тайланд тусгах:

Хуулийн 22 дугаар зүйл 22.9-д заасны дагуу албан татварын хөнгөлөлт эдлэх албан татвар төлөгч нь татварын албанаас баталсан аж ахуйн нэгжийн орлогын албан татварын ТТ-02 тайлан, хавсралт мэдээ, хөнгөлөлтийн тодруулга мэдээг бөглөж, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив авагч этгээдтэй хийсэн гэрээ, төлбөрийн баримт, бусад шаардлагатай бичиг баримтыг хавсаргаж тайлagnана.

Албан татварын хөнгөлөлт эдлэх татвар төлөгч нь хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг хасагдахгүй зардалд тусгах ба дараах шаардлагыг хангасан төлбөрийн баримтыг үйлдүүлж авсан байна.

- тухайн татварын тайлант хугацаанд хамаарсан байх;
- зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх;
- Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх;
- зардлыг тухайн үйл ажиллагаа эрхэлж байгаа албан татвар төлөгч төлсөн, эсхүл төлөхөөр тайлагнасан байх.

### **3.7.1. Албан татварын хөнгөлөлт эдлэх аж ахуйн нэгжийн хувьд:**

ААНОАТ-ын TT-02 тайлан, хавсралт мэдээ, тодруулга мэдээг бөглөж, шаардлагатай баримтыг хавсарган хуульд заасан хугацаанд илгээсэн байна.

- ✓ Тодруулга мэдээнд файлаар хавсаргах
  - Иргэний хуульд заасны дагуу гэрээ байгуулж, нотариатаар гэрчлүүлсэн гэрээг хавсаргах, бүтээн байгуулалт, төсөл хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт хийсэн бол харьяа яамандаа бүртгүүлсэн байх;
  - хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив хүлээн авагчийн олгосон төлбөрийн баримт;
  - бусад шаардлагатай бичиг баримт;
- ✓ Тодруулга мэдээ- Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлын тодруулга мэдээ /TM-1a/-г бөглөж, системээс хэрэгжүүлэх үйл ажиллагааны төрөл, зориулалт, харьяа яамдыг сонгох.

Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлын тодруулга мэдээ /TM-1a/

Д Д	Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын хүлээн авсан этгээд						Хуулийн заалт		Нийт дүн	Санхүүгийн дэмжлэг хандивын зарцуулалт/ хүлээн авч санхүүгийн тайланд тусгасан үндсэн хөрөнгийн дүн	Хяналт тавих яам			
	хүлээн авсан этгээд		ОНОО	төлбөрийн баримтын дугаар	терөл	зориулалт	дугаар	заалт						
	ТТД	нэр												
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12			

- ✓ Хавсралт мэдээ- Албан татварын хөнгөлөлтийн XM-02/8/ хавсралт мэдээг үнэн зөв бөглөж, тайлан илгээсэн байх
- ✓ Хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив хүлээн авсан этгээдээс тайлант хугацаанд зарцуулалтын ибаримт, суутгагчийн тайлангийн мэдээллийг тодруулга мэдээнд тусгана. Зөвхөн хуульд заасан зориулалтын

дагуу зарцуулсан дүнгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлэх бөгөөд ибаримт, суутгагчийн тайлангаар баталгаажаагүй дүнг хасаж тооцохгүй.

### 3.7.2. Хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив хүлээн авсан аж ахуйн нэгжийн хувьд:

- ✓ Дараах баримтыг хавсарган, хавсралт мэдээ, тодруулга мэдээг бөглөж ААНОАТ-ын ТТ-02 тайландаа дараах мэдээллүүдийг тусгаж хуульд заасан хугацаанд илгээсэн байна.
  - хөрөнгө оруулалт хүлээн авсан, санхүүгийн дэмжлэг, хандивыг орлогод төлбөрийн баримт үйлдэж, Иргэний хуульд заасны дагуу гэрээ байгуулж, нотариатаар батлуулсан байх;
  - элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд хөрөнгө оруулалт хүлээн авсан бол Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын ТТ-02 тайлангийн Үндсэн хөрөнгөд хүлээн авсан хөрөнгө оруулалтын тодруулга мэдээ /ТМ-1б/-г бөглөж, харьяа яамдыг сонгосон байх.

Хөрөнгө оруулалт хүлээн авагчийн үндсэн хөрөнгийн тодруулга мэдээ /ТМ-1б/

Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалтыг				Хуулийн заалт		Нийт дүн	Үндсэн хөрөнгийн төрөл, хэлбэр	Төлбөрийн баримтын		Хүлээн авч санхүүгийн тайланд тусгасан хөрөнгө оруулалтын дүн	Хяналт тавих яам
олгосон этгээдийн		хүлээн авсан этгээдийн		Дугаар	Залалт			дугаар	дүн		
ТТ-ийн дугаар	нэр	ТТ-ийн дугаар	нэр	5	6	7	8	9	10	11	12
НИЙТ ДҮН											

- Санхүүгийн дэмжлэг, хандив хүлээн авсан бол ТТ-02 тайлангийн Санхүүгийн дэмжлэг, хандив хүлээн авагчийн зарцуулалтын тодруулга мэдээ /ТМ-1в/-г бөглөж, харьяа яамдыг сонгосон байх

Санхүүгийн дэмжлэг, хандив хүлээн авагчийн зарцуулалтын тодруулга мэдээ /ТМ-1в/

Харилцан хамааралгүй этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивыг				Хуулийн заалт		Олгосон дүн	Хүлээн авсан санхүүгийн дэмжлэг, хандивын зарцуулалтын					Зарцуулалтын нийт дүн	Хяналт тавих яам		
олгосон этгээдийн		хүлээн авсан этгээдийн		дугаар	Залалт		нэр төрөл	төлбөрийн баримтын		сүтгэн төлөгчийн тайлагнаасан зардлын					
ТТ-ийн дугаар	нэр	ТТ-ийн дугаар	нэр					дугаар	дүн	тайлангийн төрөл	орлогтоо хүлээн авагчийн тоо	дүн			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	


- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын ТТ-02 тайлангийн хавсралт мэдээг үнэн зөв бөглөж, тайлан илгээсэн байх
- Тайлангийн тодруулга мэдээнд хүлээн авсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандивын зарцуулалтыг ААНОАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1-д заасан хасагдах зардлын нөхцөлийг хангасан баримтаар баталгаажуулан бүртгэж, тайлагнана. Тус баримт, мэдээлэл нь хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив олгосон талд хүргүүлсэнтэй адил байх бөгөөд тухайн дүнгээр олгогч этгээд нь албан татварын хөнгөлөлт өдөрнэ.

Нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлэх бүтээн байгуулалт, төслийг хэрэгжүүлэхээр хүлээн авсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандивыг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээний хэрэгжилт хангагдаагүй тохиолдолд, хөнгөлөлтийг эдлүүлэхгүй, холбогдох хууль, журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

### 3.8. Албан татварын хөнгөлөлтийн тайлан хянах, хүлээн авах

- 3.8.1. Татварын алба хуулийн 22 дугаар зүйл 22.9-д заасан нөхцөлийг хангасан, шаардлагатай баримтыг хавсарган ирүүлсэн татвар төлөгчийн жилийн эцсийн татварын тайланг хянаж, олгосон хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг, хүлээн авагч этгээдийн зарцуулалтын дүнгээр хөнгөлөлтийг тооцсон эсэх, хавсаргасан гэрээ, гэрээ дүгнэсэн акт, төлбөрийн баримт, бусад шаардлагатай баримтыг хянаж шийдвэрлэнэ.
- 3.8.2. Татварын алба албан татварын хөнгөлөлт эдлэх татвар төлөгчийн мэдээллийг жилийн тайлангийн хамт харьяа яаманд хүргүүлж батлагдсан шаардлага, стандартад нийцэж байгаа эсэхийг хянаж тодорхойлон ирүүлсэн мэдээлэлд үндэслэн шаардлага хангасан тайлангаар албан татварын хөнгөлөлтийг эдлүүлж, шаардлага хангагдаг тайланг татвар төлөгчид буцааж, засварлуулан албан татварын хөнгөлөлтийг эдлүүлэхгүй.
- 3.8.3. Татвар төлөгчийн дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор харьяа татварын албанд ирүүлсэн аж ахуйн нэгжийн тайланг хүлээн авч хянах бөгөөд албан татварын хөнгөлөлтөд хамрагдах зорилгоор хуулийн хугацаанд ирүүлснээс өөрөөр баримтыг дахин бүрдүүлэх болон шинэчлэл хийхгүй.
- 3.8.4. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйл 22.9 дэх хэсгийг татвараас зайлсхийх үндсэн зорилгоор ашигласан, хуурамч гэрээ хэлцэл хийсэн, оруулсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив нь нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулагдаагүй, гэрээний хэрэгжилт хангагдаагүй тохиолдолд албан татварын хөнгөлөлтийг эдлүүлэхгүй бөгөөд Татварын ерөнхий хуулийн 31 дүгээр зүйлд заасан хугацаанд тайланг залруулна. Хэрэв хуульд заасан тайлан залруулах хугацаа дуусгавар болсон бол холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэнэ.
- 3.8.5. Эрсдэлийн үнэлгээний системээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн татвар төлөгчийн татварын хууль тогтоомжид заасны дагуу төлбөл зохих татварын ногдлоо бүрэн гүйцэд тодорхойлж, албан татварын хөнгөлөлтийг үнэн зөв тооцоолж, тайлагнасан эсэхийг татварын алба хянан шалгана.

3.8.6. Хуулийн 22 дугаар зүйл 22.9 дэх хэсэгт заасны дагуу хөнгөлөлт эдлэх татвар төлөгчийн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан ирүүлэх, баталгаажуулах үйл ажиллагааны ерөнхий зураглалыг доор харуулав.



### 3.9. Бусад нийтлэг асуулт:

- Монголын татварын албаны цахим хуудасны түгээмэл, асуулт хариултын хэсэгт байршуулсан.

Зөвлөмж хэрэгжүүлэх

Татварын ерөнхий газрын дарга нь Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3-т заасан “зөвлөмжийг гаргах” эрхтэй бөгөөд мөн хуулийн 78 дугаар зүйлийн 78.1-д заасны дагуу татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээр гаргасан энэхүү зөвлөмжийг татварын алба үйл ажиллагаанд даа мөрдөж ажиллана.

ДАРГА



Ч.ЧИМИДСҮРЭН



**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ, ХАНДИВ ОЛГОСОН БОЛОН  
ХҮЛЭЭН АВСАН ЭТГЭЭДИЙН ТООЦООЛОЛ, ТАЙЛАНГИЙН ТУСТАХ ЖИШЭЭ  
НЭГ.САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ, ХАНДИВ**

**2.1. Санхүүгийн дэмжлэг, хандив олгосон “А” ХХК-ийн татварын хөнгөлөлтийн тооцоолол**

“А” ХХК 2025 онд харилцан хамааралгүй этгээд болох “Т” ХХК Түүхийн музейд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны баталсан А/175 тоот тушаалын шаардлага, стандартын дагуу Соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах чиглэлээр зарцуулахаар 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан этгээдтэй, гэрээ байгуулж нотариатаар баталгаажуулсан. Тайлант жилд дараах мэдээлэлтэй байв.

- борлуулалтын орлого 520.0 сая төгрөг
- хуулийн 13-р зүйлд заасан хасагдах зардал 300.0 сая төгрөг
- Ашиг 220.0 сая төгрөг
- хандивын зардал 10.0 сая төгрөг

А ХХК-ийн хөнгөлөгдөх дүн нь жилийн татвар ногдох орлого 520 сая төгрөгийн 1%-иар тооцсон дүнгээс хэтрэхгүй байх тул санхүүгийн дэмжлэг, хандивын зардлын 5.2 сая төгрөг хүртэлх дунг төлбөл зохих татвараас хасаж тооцох боломжтой. 10 сая төгрөгийн хандивын зардлыг тайлангийн хасагдахгүй зардалд тусгах бөгөөд Т ХХК-аас төлбөрийн баримт болон санхүүгийн дэмжлэг, хандивыг зориулалтын дагуу зарцуулсан талаарх баримт, мэдээллийг гаргуулан авч, гэрээг дүгнэн акт үйлдэж, зориулалтын дагуу зарцуулсан дүнгээр албан татварын хөнгөлөлт эдэлнэ.

**А ХХК нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын ТТ-02 тайлангийн дараах хавсралт мэдээ, тодруулга мэдээг тус тус бөглөнө.**

1. Нийтлэг хувь хэмжээгээр албан татвар ногдох орлогын мэдээ ХМ-02(2)-д
  - үйл ажиллагааны орлого
2. Зардлын мэдээ ХМ-02(3)-д
  - үйл ажиллагааны орлого олохтой холбогдон гарсан зардал ХМ-02(3а,3б,3г)
  - санхүүгийн дэмжлэг, хандивын зардал ХМ-02(3в)
3. Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлын тодруулга мэдээ /ТМ-1а/-д
  - Харилцан хамааралгүй этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандив

Тодруулга мэдээний хэсэгт гэрээ, төлбөрийн баримт, бусад шаардлагатай баримтыг файлаар хавсаргана.

### **Албан татварын хөнгөлөлтийн тооцоолол /ТТ-02(8)/**

Албан татварын хөнгөлөлтийн дүн		Мөр	Дүн	
<b>Албан татварын хөнгөлөлтийн нэр</b>				
22.9.3. соёлын өвийг хамгаалах, сэргээх, музей, номын сангийн үйл ажиллагаа болон хөгжим, кино, гар урлал, тайзны урлагийн бүтээл туурвих, тоглох, түгээх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор барьж байгуулах, ашиглахад харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон, хуулийн 13.1.1, 13.1.3, 13.1.4, 13.1.5-д заасан шаардлагыг хангасан санхүүгийн дэмжлэг хандивын зардал	1	Санхүүгийн дэмжлэг, хандивын зардал	9 000 000	
		Хөнгөлөлт тооцох татвар ногдох орлогын дүн	520 000 000	
		Хөнгөлөлтийн хувь	1%	
		Хөнгөлөгдөх татвар	5 200 000	
		Хөнгөлөгдөхгүй дүн	4 800 000	

**Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлын тодруулга мэдээ /ТМ-1а/**

Д Д	Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын						Хуулийн заалт		Нийт дүн	Санхүүгийн дэмжлэг хандивын зарцуулалт/ хүлээн авч санхүүгийн тайланд тусгасан үндсэн хөрөнгийн дүн	Хяналт тавих зам			
	хүлээн авсан этгээд	ТТД	нэр	огноо	төлбөрийн барилгын дугаар	терэл	зориулалт	дугаар	заалт					
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12			
1	222	A XXX	2025. 08.20	000001 23	3.хандив	Соёлын өв	22.1	Соёлын өв .....	10 000 000	9 000 000	СС АҮҮ Я			

Санхүүгийн дэмжлэг хандивын зарцуулалтын дүн нь хүлээн авсан этгээдийн тайлангийн Санхүүгийн дэмжлэг, хандив хүлээн авагчийн зарцуулалтын тодруулга мэдээ /ТМ-1в/- ийн мэдээлэлтэй зөрүүгүй байна.

## **Монголын Татварын Алба**

Маягт ТТ-02

### **АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЙЛАН**

Татварын жил:  2 0 2 5		(төгрөгөөр)					
Үзүүлэлтүүд				Mөр	Дүн		
<b>А. Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулах албан татварын тооцоолол:</b>							
<b>1. Нийт орлогын дүн (2+3+4+5)</b>							
1.1. Татвараас чөлөөлөгдхөх орлого				2			
1.4. Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдох орлого (6+8+...+16)				5	520 000 000		
Бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлого				6	520 000 000		
.....				...			
<b>2. Нийт зардлын дүн (18+19+20)</b>							
2.1. Борлуулсан бүтээгдэхүүний ёртөг				18	300 000 000		
2.2. Удирдлагын болон борлуулалтын үйл ажиллагааны зардал				19			
2.3. Үндсэн бус үйл ажиллагааны зардал				20	10 000 000		
<b>3. Татварын өмнөх ашиг +, алдагдал - (1-17)</b>							
10. Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого (26-27)				28	220 000 000		
11. Ногдуулсан төлбөл зохих албан татвар (28 * хуулийн 20.1, 20.2.7-д заасан хувиар)				29	22 000 000		
12. Хуулийн 22.5, 22.9-д заасны дагуу хөнгөлөгдөх татвар				30	5 200 000		
<b>13. НИЙТЛЭГ ХУВЬ ХЭМЖЭЭГЭЭР НОГДУУЛСАН ТӨЛБӨЛ ЗОХИХ АЛБАН ТАТВАР</b>							
				31	16 800 000		

## 2.2. Санхүүгийн дэмжлэг, хандив хүлээн авсан “Т” ХХК ний татварын тооцоолол

“Т” ХХК түүхийн музей нь 2025 тайлант жилд дараах мэдээлэлтэй байсан.

- үйл ажиллагааны орлого 300.0 сая төгрөг
- хасагдах зардал 260.0 сая төгрөг
- хүлээн авсан хандивын орлого 10,0 сая төгрөг бол дараах бүртгэлийг хийнэ.

Үндсэн үйл ажиллагааны орлого болон хандивын орлогод төлбөрийн баримт үйлдэх бөгөөд татварын тайланд тусгаж илгээнэ. Түүхийн музей нь жилийн үндсэн үйл ажиллагааны орлогоос гадна, А ХХК-д 10.0 төгрөгийн төлбөрийн баримтыг олгоно.



Санхүүгийн дэмжлэг, хандив хүлээн авсан харилцан хамааралгүй этгээд нь Санхүүгийн дэмжлэг, хандивын зарцуулалтын тодруулга мэдээ /ТМ-1в/-г бөглөх бөгөөд хүлээн авсан санхүүгийн дэмжлэг, хандивыг зориулалтын дагуу зарцуулсан талаарх төлбөрийн баримт, суутган төлөгчийн тайлангийн мэдээллийг олгосон этгээдэд хүргүүлэн, гэрээг дүгнэнэ.

**“Т” ХХК нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын ТТ-02 тайлангийн дараах хавсралт мэдээ, тодруулга мэдээг тус тус бөглөнө.**

1. Нийтлэг хувь хэмжээгээр албан татвар ногдох орлогын мэдээ ХМ-02(2)-д
  - үйл ажиллагааны орлого
  - хүлээн авсан санхүүгийн дэмжлэг, хандивын орлого
2. Зардлын мэдээ ХМ-02(3а,3б,3в,3г)-д
  - үйл ажиллагааны орлого олохтой холбогдон гарсан зардал
  - хүлээн авсан санхүүгийн дэмжлэг, хандивын зарцуулалт
3. Санхүүгийн дэмжлэг, хандив хүлээн авагчийн зарцуулалтын тодруулга мэдээ /ТМ-1в/-д
  - хүлээн авсан санхүүгийн дэмжлэг, хандивын зарцуулалт

Т ХХК нь хүлээн авсан 10,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, хандивын орлогоос 9,0 сая төгрөгийг зарцуулсан бол тус дунгээр хасагдах зардлыг бүртгэнэ.

**Санхүүгийн дэмжлэг, хандив хүлээн авагчийн зарцуулалтын тодруулга мэдээ /ТМ-1в/**

Харилцан хамааралгүй этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивыг				Хуулийн заалт		Олгосон дүн	Хүлээн авсан санхүүгийн дэмжлэг, хандивын зарцуулалтын						Зарцуулалтын нийт дүн	Хянант тавих яам			
олгосон этгээдийн		хүлээн авсан этгээдийн		дугаар	заалт		нэр төрөл	төлбөрийн баримтын		сүүтган төлөгчийн тайлагнаасан зардлын							
ТТ-ийн дугаар	нэр	ТТ-ийн дугаар	нэр				дугаар	дүн	тайлангийн төрөл	орлого хүлээн авагчийн тоо	дүн						
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15			
111	A	123	T	22		10000000	Цалин			TT-11	3	1000000	1 000 000	CCA УҮЯ			
	ХХК		ХХК	.9.			ибаримт	12345	3000000				3 000 000				
				1			ибаримт	01234	5000000				5 000 000				
Нийт зарцуулалт				10000000			8 000 000		1 000 000			9 000 000					

Хүлээн авсан санхүүгийн дэмжлэг, хандивын зарцуулалтын мэдээ нь олгосон аж ахуйн нэгжийн Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлын тодруулга мэдээ /ТМ-1а-/нд татагдах бөгөөд Албан татварын хөнгөлөлтийн хавсралт мэдээ XM-02(8)-ний хөнгөлөгдөх татварын дүн байна.

## Монголын Татварын Алба

Маягт ТТ-02

### АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЙЛАН

Татварын жил: 12\_0\_12\_15\_

(төгрөгөөр)

Үзүүлэлтүүд		Мөр	Дүн
<b>А. Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулах албан татварын тооцоолол:</b>			
<b>1. Нийт орлогын дүн (2+3+4+5)</b>		1	310 000 000
1.4. Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдох орлого ( 6+8+...+16)		5	310 000 000
Бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлого		6	300 000 000
Бусад орлого		...	10 000 000
<b>2. Нийт зардлын дүн (18+19+20)</b>		17	260 000 000
<b>3. Татварын өмнөх ашиг +, алдагдал - (1-17)</b>		21	50 000 000
11. Ногдуулсан төлбөл зохих албан татвар (28 * хуулийн 20.1, 20.2.7- д заасан хувиар)		29	5 000 000
12. Хуулийн 22.5, 22.9-д заасны дагуу хөнгөлөгдөх татвар		30	
<b>13. НИЙТЛЭГ ХУВЬ ХЭМЖЭЭГЭЭР НОГДУУЛСАН ТӨЛБӨЛ ЗОХИХ АЛБАН ТАТВАР (29-30)</b>		31	5 000 000

Уг хандив ньсоёлын өвийг хамгаалах талаарх Соёлын яамны шаардлага, стандартын баталсан нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжсэн, хандив тусламжаар нийлүүлж буй тоног төхөөрөмж нь аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, орчин үеийн шинэ техник, технологид нийцсэн байх шаардлагыг хангасан байна. Үүнээс гадна дараах тусгай шаардлагад нийцсэн байна.

- Төрийн болон орон нутгийн өмчийн музей, галерей, номын сангийн соёлын биет өвийг сэргээн засварлах, Соёлын өвийг хамгаалах байгууллага, өвлөн уламжлагч, угсаатны бүлэг, хамт олны соёлын биет бус өвийг сэргээн амилуулах, соёлын өвийн эх төрх, бүрэн бүтэн байдалд нөлөөлж буй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн байх;
- Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг сэргээн засварлах, эх төрх, бүрэн бүтэн байдал, оршин тогтоно чадварыг бэхжүүлэх олон нийтэд түгээн сурталчлахад чиглэсэн байх;
- Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоог шат шатанд бэхжүүлж, өгөгдөл боловсруулах, дамжуулах, хадгалах, ашиглах үйл ажиллагааны зохион байгуулалтыг боловсронгуй болгон, мэдээллийн систем, сүлжээ, сангийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн байх;
- Хилийн чанадад хадгалагдаж байгаа Монголчуудын бүтээсэн ба Монголчуудын түүх, соёлд холбогдох соёлын биет өвийг бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, өмчлөгч, эзэмшигчийн хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн олон талт хэлбэрээр ашиглахад чиглэсэн байх;
- Соёлын өвийн эх төрх, бүрэн бүтэн байдал, оршин тогтоно чадварыг бэхжүүлэх, соёлын өвийн баялаг байдлыг олон талт агуулга, хэлбэрээр хөгжүүлэх зорилгоор бүртгэн баримтжуулах, судлан шинжлэх, хадгалж хамгаалах, сэргээн засварлах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа байх;
- Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй соёлын өв байх, бүртгэлгүй болон бүртгэгдэж амжаагүй өв бол бүртгэлд заавал бүртгүүлсэн байх

## **ХОЁР.ЭЛЭГДЭЛ ТООЦОХ ҮНДСЭН ХӨРӨНГӨД ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**

### **2.1. Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд хөрөнгө оруулсан “У” ХХК-ийн татварын хөнгөлөлтийн тооцоолол**

Х аймаг сургуулийн барилга шаардлагатай байгаа бөгөөд боловсролын яамнаас батлагдсан бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагааны хүрээнд хийгдэхээр батлагдсан. “У” ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд уг сургуулийн барилгыг барих шийдвэр барилгын төлөвлөлт, ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал, шаардлага стандартад нийцсэн барилгыг 2025 онд нийт 1,5 тэрбум төгрөгийг зарцуулан барьж улсын комисст хүлээлгэн өгч, нийслэл, орон нутгийн өмчид бүртгүүлсэн.

“У” ХХК Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.9-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийж албан татварын хөнгөлөлт эдэлнэ. Тайлант жилд дараах мэдээлэлтэй байв.

- үйл ажиллагааны орлого 5 520.0 сая төгрөг
- хуулийн заасан нөхцөлийг хангасан хасагдах зардал 4 300.0 сая төгрөг
- ашиг 1 220 сая төгрөг
- хөрөнгө оруулалтын зардал 1 500.0 сая төгрөг

“У” ХХК -ийн жилийн татвар ногдох орлого 5 520 сая төгрөг, 55.2 сая хүртэл төгрөгийн хөрөнгө оруулалтыг төлбөл зохих татвараасаа хасаж хөнгөлөлт эдлэх боломжтой. У ХХК нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын ТТ-02 тайлангийн дараах хавсралт мэдээ, тодруулга мэдээг тус тус бөглөнө.

1. Нийтлэг хувь хэмжээгээр албан татвар ногдох орлогын мэдээ ХМ-02(2)-д

- үйл ажиллагааны орлого

2. Зардлын мэдээ ХМ-02(3)-д

- үйл ажиллагааны орлого олохтой холбогдон гарсан зардал ХМ-02(За,Зб,Зг)
- хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандивын зардал ХМ-02(3в)

3. Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлын тодруулга мэдээ /ТМ-1а/-д

- харилцан хамааралгүй этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандив
- элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт

Тодруулга мэдээний хэсэгт гэрээ, төлбөрийн баримт, бусад шаардлагатай баримтыг файлаар хавсаргана. Борлуулалтын орлого болох 5 520,0 сая төгрөгийн 1%-иар тооцсон дүнгээс хэтрэхгүй тул албан татварын хөнгөлөлтийн дүн 55,2 сая төгрөгийг төлөх татвараас шууд хасаж хөнгөлөлт эдэлнэ.

**Албан татварын хөнгөлөлтийн тооцоолол /ТТ-02(8)/**

Албан татварын хөнгөлөлтийн дүн	Мөр	Дүн	
<b>Албан татварын хөнгөлөлтийн нэр</b>			
22.9.9.төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд олгосон, хуулийн 13.1.1, 13.1.3, 13.1.4, 13.1.5-д заасан шаардлагыг хангасан санхүүгийн дэмжлэг, хандивын зардал	1	Санхүүгийн дэмжлэг, хандивын зардал	1 500 000 00
		Хөнгөлөлт тооцох татвар ногдох орлогын дүн	5 520 000 000
		Хөнгөлөлтийн хувь	1%
		Хөнгөлөгдхө татвар	55 200 000
		Хөнгөлөгдөхгүй дүн	

**Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлын тодруулга мэдээ /ТМ-1а/**

Д Д	Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын					Хуулийн заалт		Дүн	Санхүүгийн дэмжлэг хандивын зарцуулалт/ хулээн авч санхүүгийн тайланд тусгасан чадсан хөрөнгийн дүн	Хянант тавих яам
	хүлээн авсан этгээд		огноо	телбөрийн баримтлын дугаар	терел	зориулалт	дугаар	заалт		
	ТТД	нэр								
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	...	ЗДТГ	2025. 08.20	000001 23	1.хөрөнгө оруулалт	Сургуулийн барилга	22. 9.9	төрийн болон ..	1500000000	1 500 000 000 БЯ

# Монголын Татварын Алба

Маягт ТТ-02

## АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЙЛАН

Татварын жил: 2\_0\_2\_5\_

Тухайн тайлант хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй бол | | энд тэмдэглэнэ үү.

(төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	Мөр	Дүн
<b>A. Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулах албан татварын тооцоолол:</b>		
<b>1. Нийт орлогын дүн ( 2+3+4+5 )</b>	1	<b>5 520 000 000</b>
1.1. Татвараас чөлөөлөгдөх орлого	2	
1.2. Тусгай хувь хэмжээгээр татвар ногдох орлого (32)	3	
1.3. Бусад орлогын дүн (Гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит бус орлого Г.М.)	4	
1.4. Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдох орлого ( 6+8+...+16 )	5	<b>5 520 000 000</b>
Бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлого	6	<b>5 520 000 000</b>
.....		...
<b>2. Нийт зардлын дүн (18+19+20)</b>	17	
2.1. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	18	<b>4 300 000 000</b>
2.2. Удирдлагын болон борлуулалтын үйл ажиллагааны зардал	19	
2.3. Үндсэн бус үйл ажиллагааны зардал	20	<b>1 500 000 000</b>
<b>3. Татварын өмнөх ашиг +, алдагдал - (1-17)</b>	21	<b>1 220 000 000</b>
<b>10. Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого (26-27)</b>	28	<b>1 220 000 000</b>
<b>11. Ногдуулсан төлбөл зохих албан татвар (28 * хуулийн 20.1, 20.2.7- д заасан хувиар)</b>	29	<b>122 000 000</b>
<b>12. Хуулийн 22.5, 22.9-д заасны дагуу хөнгөлөгдөх татвар</b>	30	<b>55 200 000</b>
<b>13. НИЙТЛЭГ ХУВЬ ХЭМЖЭЭГЭЭР НОГДУУЛСАН ТӨЛБӨЛ ЗОХИХ АЛБАН ТАТВАР (29-30)</b>	31	<b>66 800 000</b>

### 2.2. Үндсэн хөрөнгөд хөрөнгө оруулалт авсан Х аймгийн барилгыг хүлээн авах этгээдийн бүртгэл, тайлагнал

Х аймаг сургуулийн барилга шаардлагатай байгаа бөгөөд Боловсролын яамны хэрэгжүүлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагааны жагсаалтад батлагдсан. “У” ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд уг сургуулийн барилгыг барьж, орон нутагт хүлээлгэн өгсөн бөгөөд Х аймгийн ЗДТГ нь орон нутгийн өмчид бүртгэнэ.



Үл хөдлөх хөрөнгө хүлээн авсан этгээд нь санхүүгийн тайландаа элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэх бөгөөд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын ТТ-02 тайлангийн дараах хавсралт мэдээ, тодруулга мэдээг тус тус бөглөнө.

#### 1. Нийтлэг хувь хэмжээгээр албан татвар ногдох орлогын мэдээ XM-02(2)-д

- үйл ажиллагааны орлого

- хүлээн авсан санхүүгийн дэмжлэг, хандивын орлого

## 2. Зардлын мэдээ ХМ-02(3)-д

- үйл ажиллагааны орлого олохтой холбогдон гарсан зардал ХМ-02(3а,3б,3г)

## 3. Үндсэн хөрөнгөд хүлээн авсан хөрөнгө оруулалтын тодруулга мэдээ /ТМ-16/-д

- элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд хүлээн авсан хөрөнгө оруулалт

Хэрэв хүлээн авсан тухайн хөрөнгөд санхүүгийн зорилгоор элэгдэл тооцсон бол татварын тайлангийн хасагдахгүй зардлын ХМ-02(3в) хавсралт мэдээнд тусгана.

Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалтыг хүлээн авсан этгээд нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу бусад орлого, зардлаа тайлагнах бөгөөд 22 дугаар зүйл 22.9-д заасан албан татварын хөнгөлөлттэй холбоотой Үндсэн хөрөнгөд хүлээн авсан хөрөнгө оруулалтын тодруулга мэдээ /ТМ-16/-г бөглөж, тайлагнана.

Хөрөнгө оруулалт хүлээн авагчийн үндсэн хөрөнгийн тодруулга мэдээ /ТМ-16/

Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалтыг				Хуулийн заалт		Нийт дун	Үл хөндлөх хөрөнгийн төрөл, хэлбэр	Төлбөрийн баримтын		Хүлээн авч санхүүгийн тайланд тусгасан хөрөнгө оруулалтын дун	Хяналт тавих яам
олгосон этгээдийн	хүлээн авсан этгээдийн	дугаар	заалт	дугаар	дун			дугаар	дун		
ТТ-ийн дугаар	Нэр	ТТ-ийн дугаар	Нэр								
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
111	У ХХХ	123	ЗДТГ	22.9.1	.....	1.5 т.б ₮	Сургуулийн барилга	...	1.5 т.б ₮	1500000000	БЯ
<b>НИЙТ</b>										<b>1500000000</b>	

## Монголын Татварын Алба

Маягт ТТ-02

### АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЙЛАН

Татварын жил: |2\_|0\_|2\_|5|

Тухайн тайлант хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй бол |✓| энд тэмдэглэнэ үү.

(тегрөгөөр)

Үзүүлэлтүүд		Mөр	Дун
<b>A. Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулах албан татварын тооцоолол:</b>			
1. Нийт орлогын дун ( 2+3+4+5 )		1	
13. НИЙТЛЭГ ХУВЬ ХЭМЖЭЭГЭЭР НОГДУУЛСАН ТӨЛБӨЛ ЗОХИХ АЛБАН ТАТВАР (29-30)		31	0

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын ТТ-02 тайлан гарган хуулийн хугацаанд илгээнэ.

Үг элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна.

- Боловсролын салбарт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх аж ахуйн нэгж байгууллага нь орон нутгийн Засаг дарга болон орон нутгийн боловсролын хэлтэстэй эсхүл боловсролын сургалтын байгууллагатай гэрээ байгуулсан байна
- Хөрөнгө оруулах үйл ажиллагааг олон улсын байгууллагаар дамжуулан, хамтран хэрэгжүүлэх тохиолдолд гэрээг орон нутгийн Засаг дарга, орон нутгийн боловсролын хэлтэс эсхүл боловсрол сургалтын байгууллагатай болон тухайн олон улсын байгууллагатай байгуулсан байна. /Хөрөнгө оруулах үйл ажиллагааг бусад байгууллагаар дамжуулан, хамтран хэрэгжүүлж буй тохиолдолд тус этгээдтэй холбоотой гарах зардлыг хөрөнгө оруулалтын дунд хамааруулахгүй бөгөөд албан татварын хөнгөлөлт эдлэх дунд оруулан тооцохгүй/
- Улсын комиссын дүгнэлтээр хүлээн авсан байх
- Нийслэл, орон нутгийн өмчид бүртгэгдсэн байх
- Нийслэл хотын UCS стандарт, шаардлага хангах.(энэхүү стандарт нь зөвхөн нийслэлд хамаарна)

#### **ГУРАВ. ХАРЬЯА ЯАМНЫ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Татварын алба салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хөнгөлөлтөд хамрагдахаар хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгжийн тайлан, мэдээллийг хүргүүлэх бөгөөд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар 22.11-т заасны дагуу харьяа яам хяналт тавина.

#### **ДӨРӨВ. ТАТВАРЫН АЛБАНЫ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Татвар төлөгчийн ирүүлсэн тайланг хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан эсэхийг хянаж татварын хөнгөлөлтийн мэдээллийг жилийн тайлангийн хамт салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдээллийг хүргүүлнэ. Хэрэв салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлагдсан шаардлага, стандартыг хангаагүй тухай мэдээлэл ирүүлсэн тохиолдолд татвар төлөгчийн тайланг залруулга хийлгэн, албан татварын хөнгөлөлтийг эдлүүлэхгүй.